

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС


## ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдааны 48 дугаар тэмдэглэлд:

“Х.4. Өмнөговь аймагт томилолтоор ажиллаж, стратегийн ач холбогдол бүхий Тавантолгой, Оюутолгойн ордын ашиглалт, нүүрсний тээвэрлэлт болон Цагаан хадны гаалийн хяналтын бүсийн нөхцөл байдалтай газар дээр нь танилцсан талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:

1. Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт байрлах Цагаан хадны гаалийн хяналтын бүсийн талбайн үйл ажиллагаа, экспортод гаргах нүүрсний тээвэрлэлтэд зохицуулалт хийх боломжийг судлан санал боловсруулж Засгийн газрын хуралдаанд оруулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат нарт даалгав.

2. Нүүрсний тээвэрлэлт эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд холбогдох байгууллагатай хамтран нэгдсэн шалгалт хийж, үр дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэд даалгав.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР